



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 07

Шагга

**Нэгжийн үйл ажиллагааны жилийн
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2/ж/, Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн III хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1.Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн жилийн ажлын төлөвлөгөөг Хавсралтаар баталсугай

2.Баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлт, үр дүнг хагас бүтэн жилээр Иргэдийн хурлын тэргүүлэгчдэд тайлагнахыг сургуулийн захирал /Ж.Болормаа/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Ч.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА:

Ч.АЗБАЯР



СУРГУУЛЬ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

1. **Үндэслэл** : Хөвсгөл аймгийн Засаг дарга, Боловсролын газрын дарга тус сургуулийн захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээ, аймгийн Засаг даргатай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, сургуулийн 2012-2016 он хүртэлх хөгжүүлэх хөтөлбөр, 2013-2014 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөлт зэргийг үндэслэл болгов.
2. **СУРГУУЛИЙН АЛСЫН ХАРАА** : Хүүхэд бүрийн ирэх дуртай сургах, сурах үйлийн таатай орчин бүрдсэн цогцолбор сургууль болно.
3. **СУРГУУЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**: Эрдэм боловсролтой зөв монгол хүүхдийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд сургах, сурах үйлийн шинэ орчинг бүрдүүлнэ.
4. **СУРГУУЛИЙН ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ** :
 - Багш бүр шинэ арга зүй, бүтээлч хандлагатай
 - Хүүхэд бүр өөрийн зорилготой
 - Эцэг эхчүүд бүр хүүхдэд ээлтэй
 - Ажилчид бүр хариуцлагатай, найдвартай
5. **ХУГАЦАА** : 2014 онд
6. **ХАМРАХ ХҮРЭЭ** : Цагаан-Уул сумын ЕБС-ийн багш, ажилчид, суралцагчид, орон нутгийн удирдлагууд, байгууллага хувь хүмүүс, эцэг эхчүүд төрөл бүрийн төрийн бус байгууллагууд

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын ЕБС-ийн 2013-2014 оны хичээлийн жилд дэвшигдсэн зорилго:

“ Хүүхэд нэг бүрийг судлан хөгжүүлж, сургалтын чанарт ахиц гаргана ”

№	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Хүлээгдэж буй үр дүн	Төсөвт өртөг
ЗОРИЛТ 1. Сургуулийн үйл ажиллагаа зохион байгуулалтыг боловсронгуй болгох						
1	Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх хичээл	Сар бүр	Мэргэжлийн багш нар эцэг эхчүүд	Сургуулийн захирал "Цуурай" телевиз	Эцэг эхийг сурган хүмүүжүүлэх аргад суралцуулах, эцэг эх багш, сурагчдын хамтын ажиллагааг идэвхжүүлэн багшийн үнэлэмжийг дээшлүүлнэ	570000+
2	Сум дундын эмнэлэг, аж ахуйн нэгж "Галт дулаан ОНӨҮГ зэрэг сум орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах	Жилийн турш	Сургуулийн удирдлагууд, үнэлгээний хороо, эмч, эрүүл мэнд, биеийн тамир, дуу хөгжмийн багш нар болон бусад багш, ажиллагсад, сурагчид	Сургуулийн захиргаа	Сум орон нутгийн холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан үр дүнтэй ажиллан багш ажиллагсад, сурагчдын эрүүл мэнд, ажиллах сурах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулна. Сурагчдыг эрүүл хүнсээр хангана	
3	ЗАН-ийн үйл	Жилийн	Мэргэжлийн	Сургуулийн	ЗАН-ийн үйл ажиллагаагаар	

	ажиллагааг дэмжин сайжруулна	турш	багш нар	захирал, сургалтын менежерүүд, ЗАН-ийн ахлагчид	хамтран харилцан суралцаж, багш бүр хөгжинө.
4	Хамтын ажиллагааг өргөжүүлнэ	Жилийн турш	сургуулийн бүх багш, сурагчид, ажилчид, эцэг эхчүүд	Сургуулийн захирал, БНБ-ийн багш Даваадагва, номын санч А. Долгор, сургалтын менежерүүд	Төсөл хөтөлбөр бичиж хамрагдан сургуулийн гадаад, дотоод сэтгэл зүйн болон материаллаг орчин сайжирна.
5	Гадаад болон дотоодын сургуулиудтай холбоо тогтоох	Жилийн турш	сургуулийн бүх багш, сурагчид, ажилчид.	Сургуулийн Захирал Ж. Болормаа	Сургуулийн гадаад түншлэл сайжирна. Багш ажиллагсдыг ажиллах сэдэл тэмүүлэлтэй болгоно.
6	Багш болон сургуулийн ажилтныг үнэлэх, дүгнэх журмыг хэрэгжүүлнэ	Жилийн турш	Бүх багш, ажилтан,	Сургуулийн захирал, багш, ажилтан	Багш болон сургуулийн ажилтныг дүгнэх журмыг хэрэгжүүлэн багш, сурагч, бүрт ахиц гаргана
7	Хүний нөөцийн судалгаа төлөвлөлт хийх	Жилийн турш	Бүх багш, ажилчид, сурагчид	Сургалтын менежер, сургуулийн бичиг	Сургуулийн хүний нөөцийн одоо байгаа түвшинг тодорхойлон хөгжүүлэх, төлөвлөлт хийж төсөв

				хэрэг, нийгмийн ажилтан, ня-бо	зардлыг тооцон сургалт семинарт хамруулна. Одоо байгаа түвшингээс ахиулна.	
8	Сурагчийн болон багш, ажилчдын өөрийн удирдлагын байгууллагуудыг дэмжин ажиллана	Жилийн турш	Бүх багш, сурагчид, ажилчид	Нийгмийн ажилтан У. Оюунчимэг	Хамт олныг зэрэг санаа, итгэл үнэмшилтэй болгон, нэгдмэл зорилготой болгоно.	
ЗОРИЛТ 2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх, сургалтын арга зүй технологийг суралцана.						
1	Сургалтын шинэ арга зүйд суралцах семинар зохион байгуулах	7 хоног бүр	Бүх багш нар	Сургалтын менежер Г. Тунгалаг, Б. Түвшинжаргал	Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйг бусад багш, баг хамт олныхоо туршлагаас суралцаж, сургалтанд хандах хандлагаа өөрчлөхөд нөлөөлнө	
2	Хичээлийн судалгаа	Улирал бүр	Бүх багш, сурагчид	ЗАН-ийн ахлагч Х. Даваасүрэн, М Сономванчиг, Б. Золзаая, Д. Эрдэнэжаргал	Багш бүрийн хөгжилд хувь нэмэр оруулна. Сурагч бүрийн онцлогийг судална. Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйд суралцана.	
3	Мэргэжлийн онолын шалгалт авах	3-р улиралд, 1-р	Багш нар	Захирал Ж. Болормаа, ЗАН-ийн	Багш бүр бие даан онолын мэдлэг чадвараа дээшлүүлж, ажлын байрандаа хөгжих үйл ажиллагаанд	

		улиралд		ахлагч нар	чанарын ахиц гаргана.
4	Зөвлөмж туршлага бичих	4-р улиралд	Багш нар	Менежер Г. Тунгалаг	Багш бүрийн зөвлөгөө туршлагаас суралцана. Тэдний бүтээлийг нэгтгэн эмхэтгэнэ.
5	Хичээлд сууж анализ хийх	Жилийн турш	Бүх багш нар	Сургуулийн захирал, сургалтын менежерүүд, ЗАН-ийн ахлагчид	Багшийн арга зүй технологи, сурагчдын ахиц өөрчлөлтөнд бодит дүгнэлт судалгаа хийх зөвлөн тусална.
6	"Залгамж холбоо" аян өрнүүлэх	2.3.4-р улиралд	Багш нар	Сургалтын менежер, ЗАН-ийн ахлагчид	Багш нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн ажиллах сэдэл тэмүүлэл хэрэгцээг бий болгоно.
7	"багш хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилийн турш	Багш нар	Сургалтын менежер, мэргэжлийн багш нар	Багш хөгжлийн төвийг багш бүр хөгжих үйлийн орчин болгоно.
8	Өөрийн хамгийн сайн хийж чаддаг зүйлээ хийж бусдад сурталчлах ажил зохион байгуулах	4-р улиралд	Багш нар, сурагчид	"Авьяс" ЗАН	Багш бүр өөрийн чаддаг зүйлээрээ дамжин өөрийгөө сурталчлах өөртөө илгэлтэй болно. Ажиллах урам зоригтой болно.
9	Хамтын хичээл	Жилийн турш	Багш нар	ЗАН-ийн ахлагчид	Бусад багш нараас суралцана. Өөрийгөө хөгжүүлнэ

10	Туршлага судлах	Жилийн турш	Бага ангийн багш нар, "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн бага ангийн багш нараас	Сургуулийн захирал, сургалтын менежер	Бага боловсролын туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш нарыг бэлтгэж туршлагыг зохион байгуулна.	
11	Туршилт хичээл зохион байгуулах	2014-2015 оны хичээлийн жилийн 1-р улиралд, 4-р улиралд	Бага ангийн багш нар	Сургалтын менежер Б. Түвшинжаргал	Багш нарын заах арга ур чадварыг нэмэгдүүлнэ. Туршилтыг амжилттай зохион байгуулна	
ЗОРИЛТ 3. Хүүхэд бүрийн онцлогийг судалж, тэдний хөгжил, төлөвшил, хандлага чадварт ахиц гаргана.						
1	Дэвтэр сурагчийн толь	3-р улиралд	1-5-р ангийн сурагчид	4-р ангийн АУБ нар	Дэвтрин ажиллагаагаар дамжуулан аливаа зүйлийг цэгцтэй зөв хийх аргад суралцуулна	
2	Унших чадварын судалгаа	Жилийн турш	1-5-р ангийн сурагчид	Менежер Б. Түвшинжаргал, АУБ нар	Сурагч бүрийн унших чадвар, ойлгох, ярих чадварыг судлан судалгаанд тулгуурлан багш бүр өөр өөр ажил төлөвлөн хүүхэд бүрийн унших, ярих, ойлгох	

3	ЗАН бүр хүүхдийг судлах судалгааны арга зүйд суралцах	Жилийн турш	1-12-р ангийн сурагчид	АУБ нар ЗАН-ийн ахлагчид	чадварыг хөгжүүлнэ Хүүхэд бүрийг судалснаар тэдэнд тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлж, тэдний сурах идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн зөв шийдвэр гаргахад нөлөөлнө.
4	Хүүхэд бүрийг судлах /сургуулийн нэгдсэн судалгааны сантай болох /	3-р улиралд	1-12-р ангийн сурагчид	Нийгмийн ажилтан, У. Оюунчимэг, Ж. Галмандах, Ганзориг, Мянганжаргал, Чулуунцэцэг, Түмэндэмбэрэл	Сургуулийн бүх сурагчдын амьдралын орчин нөхцөл, сурах хэрэгцээ сонирхол, цаашдын зорилго, зэрэг бүхий л талаас судалж сурагч бүрийг зорилготой сурах сонирхолтой болгоно.
5	Математик, Физикийн аян	2-р сард	6-11-р ангийн сурагчид	БУЗАН-ийн ахлагч Б. Золзаяа, математик, физик, мэдээлэл зүйн багш нар	Математик, физикийн аян өрнүүлж, цэгцтэй зөв сэтгэх аливаа зүйлийг системчлэх, олон талаас нь харах чадварт суралцана.
6	Олимпиадын бэлтгэл хийх	3-р улиралд	1-12-р ангийн сурагчид	Сургалтын менежер Г. Тунгалаг, Б.	Авьяаслаг чадварлаг сурагчдын онцлогт тохируулан хөгжүүлэх, тэднээр дамжуулан бусдыг нь

					Түвшинжаргал	хөгжүүлнэ.	
7	ЭЕШ-д бэлтгэх	Жилийн турш	10-11-р ангийн сурагчид	Менежер Г. Тунгалаг	Хүүхэд бүрийн сонирхол хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулагдсан сонгон судлах хчизээлийн явц үр дүнд тогтмол хяналт дүн шинжилгээ хийж ажиллан ЭЕШ- д өмнөх амжилтаа ахиулна.		
8	Сурагчдын хичээл сургалтын явцад судлах	Жилийн турш	Бүх багш нар	Сургуулийн захирал	Сурагчдыг хичээлд дур сонирхолтой болгож тэднийг дэмжинэ.		
9	Дугуйлан сонгон секцийн үр дүнд анализ хийх	Жилийн турш	Мэргэжлийн багш, нар сурагчид	Сургалтын менежер Г. Тунгалаг, Б. Түвшинжаргал	Сурагчдын, хэрэгцээнд нийцэж, сонирхлыг хангахуйц сургалт зохион байгуулж, хүүхэд бүрийг байгаа төвшингээс нь ахиулна		
10	Явцын болон үе шатны үнэлгээг төлөвлөн зохион байгуулна	Улирал бүр	Бүх багш, сурагчид	Сургалтын менежерүүд, ЗАН- ийн ахлагчид, мэргэжлийн багш нар	Үнэлгээний шалгууртай үнэлэх зүйл нь тодорхой бичиж, ахицад судалгаа дүгнэлттэй байна.		
11	"Эх хэлээ дээдэлбэ" аян зохион байгуулна	2-р улиралд	Бүх сурагчид	Монгол хэл уран зохиолын багш нар	Эх хэлээрээ зөв сайхан бичих чадварт суралцана.		
12	Морин хуурын	2-р	20 сурагч	Захирал ,	Морин хуурын хамтлагтай болно.		

	дугуйлан хичээллүүлэх	улиралд		хөгжмийн багш	
ЗОРИЛТ 4. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ					
1	"Сайн гэр бүл"	4-р сард	Бүх эцэг эхчүүд орон нутгийн "Цуурай" телевиз	Нийгмийн ажилтан У. Оюунчимэг, З. Балдансамбуу	Хүүхдэдээ сурч амьдрах хөгжих таатай орчин бүрдүүлж чадаж байгаа сурган хүмүүжүүлэх зөв дадал хэвшил бүхий гэр бүлийг иргэдэд сурталчлан туршлагыг нь түгээн дэлгэрүүлнэ.
2	Сурагч-Эцэг эх	1-р сард	7.6.1-р ангийн эцэг эхчүүд	"Авьяас" ЗАН, АУБ нар	Сурагчид эцэг эхийн хоорондын үл ойлголцлыг арилгах, сургуулийн үйл ажиллагааг бусдад сурталчлах, эцэг эх, багш, сурагчдын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
3	11-р анги төгсөгчдийн эцэг эхийн өдөрлөг	2014.02.10	11а, 11б ангийн эцэг эхчүүд	Нийгмийн ажилтан У. Оюунчимэг	Эцэг эхчүүдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгал болгож, тэдэнд шаардлагатай мэдээ мэдээллээр хангана.
4	Малчин эцэг эхчүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгөх	Улирал бүр	Дотуур байранд хүүхэд нь амьдардаг эцэг эхчүүд	Сургуулийн эмч Г. Эрхэмжаргал, байрын багш нар, сургалтын менежерүүд, БНБ-ын багш, номын санч	Эцэг эхчүүдэд мэдээлэл хийх, эрүүл зан үйл, сургалтын талаар мэдээлэл өгнө. Сэтгэл ханамжийн судалгаа авна

5	Соёлын төвтэй хамтарч ажиллах	Жилийн турш	Сурагчид эцэг эхчүүд, багш нар	Биеийн тамирын багш нар, Д. Эрдэнэжаргал, С. Наранцэцэг, А. Долгор, МХУЗ-ын багш нар	Сурагчид, эцэг эхчүүд, багш нарын дунд зохиогдсон зарим үйл ажиллагаанд хамтран ажиллана.
6	Сум дундын эмнэлэгтэй хамтран ажиллах	Жилийн турш	Бүх багш ажилчид, сурагчид	Эмч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн багш	Эрүүл ахуйн зөв дадал, эрүүл мэндийн зөв боловсрол олгох үйл ажиллагаанд хамтын үйл ажиллагааг чиглүүлнэ.
7	Багш, ажилчид, сурагчид, эцэг эхчүүдийн дунд монгол хэл бичгийн сургалт зохион байгуулах	11,3-р сард	Багш, сурагчид, ажилчид, эцэг эхчүүд	МХУЗ-ын багш нар	Монгол хэл бичгийн мэдлэг нэмэгдэнэ
8	Хөдөөгийн багт ажиллах	2-3-р улиралд	Малчид	БНБ-ын багш Д. Даваадагва	Сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэдэд хэрэгцээний бодит судалгаа хийх
ЗОРИЛТ 5. Бүх нийтийн боловсролын хүртээмж чанарыг дээшлүүлэх					
1	Дүйцсэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж	Жилийн турш	Дүйцсэн хөтөлбөрт	БНБ-ын багш Даваадагва,	Бичиг үсэг тайлагдаагүй насанд хүрэгчид болон өвчний улмаас

	төгсөгчдөд суурь болон дунд боловсрол эзэмшүүлнэ		хамрагдаж буй сурагчид	мэргэжлийн багш нар	сургууль завсардсан суралцагчдад боловсрол нөхөн олгож цаашид сурах нөхцөл бололцоог нээж өгнө	
2	"Цуурай" телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэх, олны хүртээл болгох	Жилийн турш	Сумын ард иргэд	БНБ-ын багш Д. Даваадагва	Ард иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдээ мэдээллийг арга аргачлалаар нэвтрүүлэг хийж бэлтгэн амьдрах ухаанд суралцуулна	
3	Компьютерийн сургалт	2-р сард	Сумын иргэд	Л. Баатарчулуун Д. Даваадагва	Компьютерийн анхан шатны мэдлэг чадвар дэдлэг ард иргэдэд олгох, интернэтэд орж мэдээлэл цуглуулж сурах	
4	Гамшгаас хамгаалах сургалт	3-р сард	Бүх багш, ажилчид	БНБ-ын багш Даваадагва	Галын аюул болон гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх сургалтыг бүх нийтэд хүртээмжтэй байдлаар зохион байгуулах	
5	Англи хэлний анхан шатны сургалт	2,4-р сард	Багш, ажилчид, ард иргэд	Д. Даваадагва, англи хэлний багш нар	Багш ажилчдын англи хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх	
ЗОРИЛТ 6. Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх						
1	Үдийн цай, дотуур байрны хоол хүнсэнд тогтмол хяналт тавих	Хичээлийн жилд 7 хоног бүр	Үдийн цайны тогооч, дотуур байрын тогооч, нярав, нягтлан	Байрын багш нар, сургуулийн эмч, дотоод хяналтын баг	Сурагчдыг элдэв төрлийн хордлогод оруулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээ үзүүлж, эрүүл хүнсээр хангана	

2	Дотуур байрын сурагчдын дунд эрүүл мэндийн сургалт зохион байгуулах	2.4-р улиралд	Байрын сурагчид	Байрын багш, эмч, СДЭ нэр	Суралцагчдад гарын болон амны хөндийн ариун цэврийг сахих хорт зуршлаас сэргийлэх, зөв дадал хэвшил олгоно.	
3	Сүрьеэ өвчний талаар эмчийн зөвлөгөө	03 сард	Сурагчид	Сургуулийн эмч	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	
4	Дотуур байрын хатуу эдлэлийг шинэчлэх	4-р улиралд	Байрын сурагчид	Сумын Засаг дарга, сургуулийн захирал	Дотуур байрын ширээ сандал, орыг сольж шинэчлэн эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлнэ	
5	Зураг зүй технологийн кабинет тохижуулах	4-р улиралд	Сурагчид, багш нар, ажилчид	Сумын Засаг дарга, сургуулийн захирал	Зураг зүй, технологийн кабинетийг тохижуулж суралцагчдад сэтгэл зүйн болон материаллаг таатай орчин бүрдүүлнэ	
6	"Эмчхэн" бүлгийн үйл ажиллагааг төлөвлөх, өргөжүүлэх	Жилийн турш	Сурагчид	С. Наранцэцэг	Хүүхэд бие биеэсээ суралцана.	
7	Мэргэжлийн хичээлийн кабинетүүд байгуулах	Жилийн турш	Багш нар	Сургуулийн захирал, сургалтын менежер, мэргэжлийн багш нар	Анги танхим бүрийг хүүхэд бүр хөгжих, таатай орчин болгоно.	
8	Биеийн тамирын гадна	6-р сард	Мэргэжлийн баг	Биеийн	Хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон	19,5 сая

	талбайг тохижуулах				тамирын багш нар, сургуулийн захирал, Сумын Засаг дарга	өнгөрүүлэх орчин нөхцөл бүрдэнэ.	
9	440 хүүхдийн хичээлийн байрны засвар	2014 онд	Мэргэжлийн баг	Сургуулийн захирал, Сумын Засаг дарга Аймгийн Засаг дарга	Багш, ажилчид, сурагчдын сурч боловсрох, ажиллах таатай орчин нөхцөл бүрдэнэ.	100 сая	
10	Багш нарын орон сууцыг тохижуулах, засвар хийх	2014 онд	Сургуулийн багш, ажилчид	Сумын ИТХ	Багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	10 сая	
ЗОРИЛТ 7. Хамтын бүтээлч үйлийг дэмжин үнэлж, түгээн дэлгэрүүлэх							
1	Бүтээлч ЗАН шалгаруулах	5-р сард	Бүх багш нар	ЗАН-ийн ахлагчид	Сургуулийн коридорыг тохижуулж сэтгэл зүйн таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ	250 000	
2	ЗАН-ийн ажлын чанар үрдүнд хяналт тавих	Сар бүр	Мэргэжлийн багш нар	ЗАН-ийн ахлагч, дотоод хяналтын баг	Үйл ажиллагааны чанарт ахиц гарч байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж тооцоо судалгаагаар ажиллана.		
3	Ажилчдын баяр тэмдэглэх	4-р сард	Ажилчид	Сургуулийн захиргаа	Ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, хамтдаа хөгжих боломж олгоно.	576000	
4	Бүтээлч ажилчин, баг хамт олон	Улиралд	Ажилчид	Захирал, нярав, ня-бо	Багаар хамтран хийсэн бүтээлч ажлаа бусдад сурталчлах, түгээн	480000	

	шалгаруулах						дэлгэрүүлж, урамшуулах	
5	Хамтдаа хийсэн бүтээлч ажил	Жилийн турш	Багш, ажилчид	Сургуулийн захиргаа	Хамтдаа хийхээр санаачилсан санал санаачлагыг өөрийн боломж бололцооныхоо хэрээр дэмжин ажиллана			
6	Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх	5-р сард	Багш, сурагчид, ажилчид, ард иргэд	МХУЗ-ын багш нар	Үндэсний бичиг үсгийн өдөрлөг зохион байгуулах			
7	Бүсэд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Жилийн турш	Бүсийн багш, ажилчид, сурагчид	Бүсийн сургуулиудын захирлууд	Бүсийн хамтын ажиллагааг өргөжүүлж чанаржуулна.			
ЗОРИЛТ 8. "Авьяас", "Ном", "Багшийн хөгжил" хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлж, олны хүртээл болгох								
1	"Авьяас", "Ном", "Багшийн хөгжил" хөтөлбөрийн комисс томилон тусгай хөтөлбөр гаргаж дүнг тооцож ажиллана	Жилийн турш	Багш, сурагчид, ажилчид	Сургуулийн захирал, тушаалаар томилогдсон комисс	"Авьяас", "Ном", "Багшийн хөгжил" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн ажил зохион байгуулах			
2	"Бие биелгээ сурцгаая"	Жилийн турш	ЕБС-ийн сурагчид, АУБ нар	Нийгмийн ажилтан	Шаталсан үйл ажиллагаа зохион байгуулж сургуулиараа бие биелгээг хийж сурна			
3	"Авьяас" хөтөлбөрийн тайлан	1,6-р сард	ЕБС-ийн сурагчид	Хөтөлбөрийн комисс	Юу сурчы мэдснээ эцэг эхчүүд, иргэдэд тайлагнах, бусдаас			

						суралцах	
4	"Ном" хөтөлбөрийн тайлан	4-р сард	ЕБС-ийн сурагчид,	"Ном" хөтөлбөрийн комисс	Номтой нөхөрлөсний ач тусыг мэдрэх, номонд дуртай болох, түүгээрээ дамжуулан зөв төлөвшилтэй болно.		
5	Номын фондыг нэмэгдүүлнэ	Жилийн турш	Багш, сурагчид	Сургуулийн захирал	Номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.		
6	Зөврийн номын санг тохижуулан баяжуулах	Жилийн турш	АУБ нар, дотуур байрын багш нар	Номын санч	Сурагчдыг ном унших сонирхолтой болгох орчин нөхцөлийг бүрдүүлнэ		
7	"Зумба фитнес" сурах	10,11-р сард	Багш, ажилчид, сурагчид, эцэг эхчүүд	С. Наранцэцэг, Нандин-Эрдэнэ, Г. Эрхэмжаргал	Сургуулийнхаа бүх сурагчдад "Зумба фитнес" эрүүл зөв хөдөлгөөн сургана.		
8	Эрүүл мэндийн өдөртэй болох, ажлын байрны дасгал сурах	7 хоног бүрийн 3 дахь өдөр	Багш, ажилчид, сурагчид, эцэг эхчүүд	Биеийн тамирын багш нар сургуулийн эмч,	Хамт олноороо эрүүл зөв хөдөлгөөнд суралцах, эрүүл мэндийн зөв дадал хэвшилд суралцана.		
ЗОРИЛТ 9. "Экологийн боловсрол олгох" үйл ажиллагааг чанаржуулах , дэмжих							
1	Эко клубын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах	9-р сард	Сурагчид	Эрдэнэ-Очир, С. Наранцэцэг	Экологийн боловсролыг хүүхэд бүрт хүн бүрт олгохыг зорино		
2	Экологийн боловсрол олгох хичээлийг төлөвлөх	10-р сард	Багш, сурагчид	Мэргэжлийн багш нар, АУБ нар	АУБ бүр ангийн ажлын төлөвлөгөөнд тусгаж хүүхэд бүрд эх орон газар дэлхийгээ хайрлах		

							сэтгэлгээг төлөвшүүлнэ.
3	Мод тарих, арчлах	Намар хаврын улиралд	Багш, сурагчид	Наранцэцэг, Азбилэг	Наранцэцэг, Азбилэг	Сургуулийн орчин тойрныг цэцэрлэгжүүлэн мод тарих, тарьсан модоо арчлах тордож эрүүл цэвэр орчин бүрдүүлнэ	
4	"1000 цэцгийн баяр"	5.10-р сард	Багш, сурагчид	Наранцэцэг, Азбилэг	Наранцэцэг, Азбилэг	Анги, танхим, өрөө тасалгааг цэцэгжүүлж сурагчдад сурах, багш ажилчдад ажиллах таатай орчин нөхцөл бүрдэнэ	
5	Мод тарих аргачлал сургалт	4-р сард	Сурагчид, багш нар ажилчид	Наранцэцэг, Азбилэг	Наранцэцэг, Азбилэг	Мод тарих арга аргачлал, модны терел ангиллыг мэдэх	
6	Цэцэг тарих нэр төрлийг олшруулах сургалт	3-р сард	Сурагчид, багш нар ажилчид	Наранцэцэг, Азбилэг	Наранцэцэг, Азбилэг	Цэцэг тарих аргачлал, цэцгийн нэршил мэдэх	
7	"Эх орон эх, дэлхийгээ хайрлая" аян	5-р сард	АУБ нар, сурагчид	Наранцэцэг Нийгмийн ажилтан У. Оюунчимэг	Наранцэцэг Нийгмийн ажилтан У. Оюунчимэг	Эх орон, газар шороо, ой модоо хайрлан хамгаалах, сэтгэл зүйн зөв төлөвшил олгоно	
ЗОРИЛТ 10. Эрүүл зан үйл төлөвшүүлэх							
1	"Ахмадуудад тусалъя" аян	9-р сард	АУБ нар сурагчид	Нийгмийн ажилтан У. Оюунчимэг	Нийгмийн ажилтан У. Оюунчимэг	Ахмад настуудад очиж туслан тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх	
2	"Хайрлая, хамгаалъя" аян	11.4-р сард	АУБ нар сурагчид	Нийгмийн ажилтан У.	Нийгмийн ажилтан У.	Анги танхим, өрөө тасалгааныхаа эд хогшлыг хайрлан хамгаалж цэвэр	

				Оюунчимэг , нярав Цагаанбаатар, эмч Г. Эрхэмжаргал	цэгцтэй байх	
3	"Хүн ахтай дээл захтай "уламжлалт ёс заншлаас суралцах	1-р сард	АУБ нар, сурагчид, ажилчид	Нийгмийн ажилтан У. Оюунчимэг, байрын багш нар БНБ-ын багш Даваадагва, МХУЗ-ын багш нар	Уламжлалт ёс заншлаа мэдэж , аж амьдралдаа зөв дадал хэвшилтэй болно.	
4	Зөв сайхан мэндэлж сурцгаая	Жилийн турш	Сурагчид багш нар, ажилчид	Нийгмийн ажилтан , байрын багш нар	Харилцааны хамгийн чухал зүйл болох мэндлэх хүндлэх ёсыг сурна.	
5	"Хараалын үг цээрлэж, ерөөлийн үгийг тогтооё"	12,3-р сард	АУБ нар, сурагчид, ажилчид	МХУЗ-ын багш нар	Хамгийн олон ерөөлийн үг чээжилсэн сурагчдыг шалгаруулна. Бусдад сурталчлан түгээн дэлгэрүүлнэ.	
6	Хувийн соёл сургалт	11-р сард	АУБ нар, сурагчид	Түмэндэмбэрэл нийгмийн	Олон нийтийн газар биеэ зөв авч явах, харилцааны энгийн	

			ажилчид	ажилтан У. Оюунчимэг	дүрмүүдийг мэдэх
7	Багш нар сурагчдад эрүүл зөв зан үйл төлөвшүүлэх	Жилийн турш	Сурагчид, багш нар, ажилчид	Нийгмийн ажилтан, сургалтын менежер	Сурагч бүр мэндлэх, хүндлэх байгаа орчноо цэвэр байлгах, хог хаяхгүй байх дадал хэвшилтэй болно.

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН :

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ж. БОЛОРМАА